



БАРАА МАТЕРИАЛ

БЭЛТГЭН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

2021 онь *01* дугаар сар *04*

№

Говьсүмбэр аймаг

Нэг талаас 4615867 регистрийн дугаар бүхий *Зэнэдмэнэ буян арвижих эрдэнэ ХХК* /цаашид нийлүүлэгч гэх/-ыг төлөөлж *захирал* албан тушаалтай *Чулуунбаатар овогтой Нарантуяа*, Нөгөө талаас 9020314 регистрийн дугаар бүхий *Говьсүмбэр аймгийн Боловсрол Соёл Урлагын газар* /цаашид Худалдан авагч гэх/ төлөөлж Нягтлан бодогч албан тушаалтай *Номинзул овогтой Одонтуяа* нар харилцан тохиролцов.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Гэрээний нөхцлийн дагуу худалдагч нь стандарт шаардлага хангасан бараа бүтээгдэхүүн, техник тоног төхөөрөмж болон түүнтэй холбоотой баримт бичгийг худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх, худалдан авагч нь бараа бүтээгдэхүүнийг хүлээн авч, төлбөрийг хийнэ.
- 1.2 Шаардлагатай бусад тоног төхөөрөмж, бараа бүтээгдэхүүнийг захиалгын дагуу бэлтгэн нийлүүлэх үйлчилгээг үзүүлж, төлбөрийг хүлээн авна.
- 1.3 Гэрээний үнэ болон төлбөр хийх хугацааг харилцан тохиролцож болно.

ХОЁР: НИЙЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

- 2.1 Худалдан авагчийн захиалгыг хүлээн авч захиалгын дагуу бараа бүтээгдэхүүнийг заасан хугацаанд нийлүүлнэ.
- 2.2 Хэрэглээний стандарт шаардлагад нийцсэн бараа бүтээгдэхүүнийг өргөн нэр төрлөөр худалдаална.

2.3 Борлуулалтын баримт бичиг хөтлөх

2.4 Бараа бүтээгдэхүүнийг зарлагын баримт, нэхэмжлэхийн хамтаар худалдан авагчид шилжүүлнэ.

2.5 Төлбөрийг гэрээнд заасан хэмжээгээр хүлээн авах

2.6 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг худалдан авагчаас шаардах.

2.7 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

ГУРАВ: ХУДАЛДАН АВАГЧИЙН ЭРХ ҮҮРЭГ

3.1 Нийлүүлэгчээс чанар болон эрхийн доголдолгүй бараа бүтээгдэхүүн худалдаалах шаардах.

3.2 Шаардлагатай бараа бүтээгдэхүүний захиалгыг урьдчилан өгөх эсвэл шууд худалдан авах.

3.3 Нийлүүлсэн бараа бүтээгдэхүүнийг шалгаж хүлээн авах ба ашиглах явцад илэрсэн доголдолыг нийлүүлэгч талд ажлын 3 хоногийн дотор мэдэгдэх.

3.4 Хөрөнгийг хүлээн авахдаа тоо, чанар, иж бүрдэлийг шалгаж, холбогдох баримт бичгийг бүрдүүлнэ.

3.5 Нийлүүлэгч тал гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн болон биелүүлээгүйгээс өөрт учирсан хохирлыг шаардах, нэхэмжлэх

3.6 Худалдан авсан бараа бүтээгдэхүүний төлбөрийг нийлүүлэгч талд тохирсон хугацаандаа төлөх үүрэгтэй.

3.7 Хуульд заасан бусад эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

ДӨРӨВ: ТООЦОО ХИЙХ ЖУРАМ

4.1 Худалдан авагч тал хөрөнгийн төлбөрийг нийлүүлэгч талын нэхэмжлэлд үндэслэн бэлэн бусаар шилжүүлнэ.

4.2 Худалдан авагч тал бараа бүтээгдэхүүний төлбөрийг шилжүүлсэн тухай нийлүүлэгч тал ажлын 3 хоногийн дотор мэдэгдэнэ.

ТАВ: ХӨРӨНГӨ ШИЛЖИХ

5.1 Худалдсан хөрөнгийг худалдан авагчид шилжүүлснээр хөрөнгө устаж, гэмтэсний эрсдэл худалдан авагчид шилжинэ.

5.2 Худалдан авагч хөрөнгийг хүлээн авсныг гэрчлэх тодорхой үйлдэл хийсэн бол түүнийг хөрөнгө хүлээн авсанд тооцно.

ЗУРГАА: ТАЛУУДЫН ХАРИУЦЛАГА

- 6.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ заавал биелүүлэх үүрэгтэй бөгөөд итгэл эвдэхгүй байх зарчмыг мөрдлөгө болгоно.
- 6.2 Нийлүүлэгчийн буруугаас хөрөнгийг хугацаанд нь шилжүүлээгүй тохиолдолд хоног дутам шилжүүлээгүй хөрөнгийн үнийн дүнгийн 0.5 хувиар тооцож худалдан авагчид торгууль төлнө.
- 6.3 Худалдан авагч нь бараа материалын төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш өөрийн буруугаас шилжүүлээгүй тохиолдолд хоног дутам биелүүлээгүй гэрээний үүргийн үнийн дүнгийн 0,5 хувиар тооцож нийлүүлэгчид торгууль төлнө.
- 6.4 Худалдсан хөрөнгийн үнэ тухайн үеийн ижил, чанар, төрлийн хөрөнгийн зах зээлийн үнээс илт зөрүүтэй бол талууд хөрөнгийн үнийн зөрүүг арилгах үүрэгтэй.
- 6.5 Энэ гэрээний нөхцлийг зөрчснөөс аль нэг талууд шууд хохирол учирвал нөгөө тал хохирлыг арилгаж, барагдуулна.
- 6.6 Тохиролцсон үнийг нэг талын санаачлагаар өөрчлөхгүй байх.

ДОЛОО: ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

- 7.1 Давагдашгүй хүчин зүйл /үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр, оролцоо гэх мэт/-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилгах хүртэл хугацаагаар хойшлуулах болно.
- 7.2 Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.
- 7.3 Тухайн нөхцөл байдлын улмаас гэрээний үүргийн хугацаа 7 болон түүнээс дээш хоногоор хойшлогдвол талуудын аль нэг нь гэрээний үүргээ биелүүлэхээс татгалзаж болно. Энэ тохиолдолд хохирол төлүүлэхийг шаардахгүй.

НАЙМ: МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

- 8.1 Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.
- 8.2 Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын Хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

ЕС: ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨХ БОЛОХ, ҮЙЛЧЛЭХ ХУГАЦАА

- 9.1 Энэхүү гэрээнд талуудын эрх бүхий төлөөлөгч нарт гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсан өдөр хүчин төгөлдөр болсонд тооцно.
- 9.2 Гэрээний үйлчлэх хугацаа 2021 оны 01 сарын 04 өдрөөс 2021 оны 12 сарын 31 өдөр хүртэл байна.
- 9.3 Гэрээний хугацааг 2 тал бичгээр тохиролцсноор сунгаж болно.

9.4 Дараахь тохиолдолд гэрээ дуусгавар болсон нь талуудын нэг нэгнийхээ өмнө биелүүлээгүй байсан болон байгаа үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.4.1 Талууд зөвшилцснөөр

9.4.2 Монгол Улсын эрх бүхий байгууллагын шийдвэрээр

9.4.3 Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр

АРАВ: БУСАД ЗҮЙЛ

10.1 Гэрээг 2% үйлдэж, тал тус бүр нэг нэг хувийг хадгална.

10.2 Талууд энэхүү гэрээнд аливаа нэмэлт, өөрчлөлт оруулахдаа харилцан тохиролцож, бичгээр нэмэлт өөрчлөлт оруулна.


10.3 Гэрээний нэмэлт, өөрчлөлт нь энэхүү гэрээний салшгүй хэсэг байна.

10.4 Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол Улсын Иргэний хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдлөгө болноно.

Гэрээ байгуулсан:

Худалдан авагч тал:

Говьсүмбэр аймгийн Боловсрол Соёл Урлагын

газрын Нягтлан бодогч  Н.Одонтуйа

Утас: 70543160



Нийлүүлэгч тал:

Зэндмэнэ буян арвижих эрдэнэ


ХХК-ны захирал  Ч.Нарантуяа

Утас: 99049552



Батлав: "Алхана трейд" ХХК-ийн

ГСА дахь салбарын Дарга



/Г.Оюунцэцэг /

Батлав: Говьсүмбэр аймаг БСУГ-ын

Дарга  А.Зургаанжин /



№

ТАЛОНООР ШАТАХУУН НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ /БАЙГУУЛЛАГА/

2021 оны 01 сарын 03 өдөр

Чойр

Нэг талаас нефтийн бүтээгдэхүүн импортлогч "Алхана трейд" ХХК-ийг төлөөлж Салбарын дарга Г.Оюунцэцэг (цаашид Нийлүүлэгч гэх), нөгөө талаас БСУГгазар -ыг төлөөлж дарга албан тушаалтай (цаашид үйлчлүүлэгч байгууллага гэх) А.Зургаанжин нар харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээний зорилго нь тус үйлчлүүлэгч байгууллага болон ШТС-ийн үйлчилгээг түргэн шуурхай, найдвартай тасралтгүй үзүүлэхэд оршино.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Нийлүүлэгчээс олгосон шатахууны талон нь зөвхөн шатахуун худалдан авахад зориулагдсан болно.
- 1.2 Шатахуун түгээх талоньг урьдчилан худалдаж авах нь "Сод монгол Групп" ХХК-ийн аль ч салбар ШТС-аар талоны үнийн дүнтэй тэнцэх шатахуунаар үйлчлүүлэх үндэслэл болно.
- 1.3 Худалдан авагч тал нь өөрийн ажил үйлчилгээний хэрэгцээнд сард / / төгрөгийн шатахууныг зээлийн нөхцлөөр авна.
- 1.4 Нийлүүлэгч тал нь шатахууны талонгоор тухайн үеийн зах зээлийн тухайн ШТС-ын жижиглэнгийн жишиг үнээр шатахуун нийлүүлэх үйлчилгээ үзүүлнэ. Үнийн дүнд НӨАТ тооцсон байна.
- 1.5 Талууд энэхүү гэрээгээ хүндэтгэн үзэж, гэрээнд дурдсан ажил үйлчилгээг бусад төрлийн байгууллагаас авахгүй байхыг эрхэмлэнэ.

Хоёр. Гэрээний хугацаа

- 2.1 Энэхүү гэрээ нь 2021 оны 01 –р сарын 03 -аас 2021 оны 12–р сарын 31 -ны өдрийг дуустал хугацаанд хүчинтэй байна.
- 2.2 Гэрээний 2.1 дэх хэсэгт заасан хугацаа дуусгавар болоход талуудын аль нэг нь гэрээг дуусгавар болгох санал тавиагүй бол Гэрээг энэхүү гэрээнд заасан нөхцлөөр дахин нэг жилээр сунгасанд тооцно.

Гурав. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

- 3.1 Нийлүүлэгч талын шатахуун түгээх станцууд нь үйлчлүүлэгчийн худалдан авсан шатахууны талоны үнийн дүнгийн хэмжээгээр шатахуун олгох үйлчилгээг үзүүлнэ

- 3.2 Зах зээлд шатахууны хомсдол үүссэн тохиолдолд гэрээт байгууллагын шатахууны хэрэгцээг тухайн үеийн нөхцөл байдалд тохируулан тэргүүн ээлжинд хангах ажлыг зохион байгуулна.
- 3.3 Нийлүүлэгч тал нь ОУ-ын болон МУ-ын зохих стандартад бүрэн нийцсэн шатахуунаар үйлчлүүлэгчийг хангах бөгөөд стандарт шаардлагад нийцээгүй шатахуун нийлүүлснээс үүдэн гарах хохирлыг барагдуулна.

Дөрөв.Үйлчлүүлэгчийн эрх, үүрэг

- 4.1 Үйлчлүүлэгч нь худадан авах шатахуун талоны тоо хэмжээний урьдчилсан захиалгыг 2-оос доошгүй хоногийн өмнө өгч баталгаажуулж байна.
- 4.2 Үйлчлүүлэгч нь барааны чанарыг шалгаж, хүлээн авах үүрэгтэй. Энэхүү үүргээ биелүүлээгүйгээс учирч болзошгүй эрсдлийг үйлчлүүлэгч өөрөө хариуцна.
- 4.3 Тослох материалын төлбөр бэлнээр болон талоноор хийгдэж явна.

Тав.Төлбөр тооцооны нөхцөл

- 5.1 Үйлчлүүлэгч тал нь шатахуун худалдан авах зориулалтаар үнийг “Алхана трейд” ХХК – ны харилцах дансанд тухайн сарын 25-аар тасалбар болгон төлнө.*
- 5.2 Үйлчлүүлэгч нь худалдан авах шатахууны төрөл, тоо хэмжээ, хүлээн авах хугацаа зэргийг заасан захиалгыг худалдагч талд бичгээр мэдэгдэх бөгөөд энэхүү хүлээн авсан захиалгыг үндэслэн төлбөрийн нэхэмжлэхийг Үйлчлүүлэгч талд хүргүүлнэ.
- 5.3 Талоны төлбөрийг дор дурдсан “Алхана трейд” ХХК-ийн банкин дах харилцах дансанд шилжүүлнэ.

Худалдагчийн банк	Данс	Дансны дугаар
ХААН БАНК	Төгрөгийн	5031386162

- 5.4 Нийлүүлэгчийн харилцах дансанд өмнөх сарын талоны төлбөр шилжиж орсноор Үйлчлүүлэгч талын итгэмжлэгдсэн төлөөлөгч дахин шатахуун авах талоноо санхүүгийн баримтын хамт ШТС-аас ирж авна.
- 5,5 .Шатахууны импортын болон зах зээлийн үнэ хэлбэлзсэн нөхцөлд худалдагч тал нэгж литр шатахууны үнийг өөрчлөн тогтоох эрхтэй.
- 5,6 Зах зээлд шатахууны хомсдол гарвал гэрээт байгууллагын шатахууны хэрэгцээг хангах зорилгоор нөөц бүрдүүлэхийн тулд харилцан тохиролцож, урьдчилгаа төлбөр байршуулж болно.

Зургаа. Гэрээ цуцлах, дуусгавар болгох нөхцөл

- 6.1 Дараах тохиолдолд гэрээ дуусгавар болно. Үүнд:
- 6.1.1 Гэрээний хугацаа дуусаж гэрээний биелэлтийг дүгнэснээр
- 6.1.2 Талууд харилцан тохиролцсоноор
- 6.1.3 Аль нэг тал гэрээнд заасан нөхцлүүдийг удаа дараа биелүүлээгүй, зөрчсөн нөхцөлд

Долоо. Бусад зүйл

- 7.1 Гэрээтэй холбогдон үүсэн гарах маргааныг талууд эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд тохиролцож чадаагүй тохиолдолд шүүхээр шийдвэрлүүлнэ.
- 7.2 Энэ гэрээний бүх нөхцөл, заалтыг эрх бүхий албан тушаалтнууд зөвшөөрснөөр 2 хувь үйлдэн гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.
- 7.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэн хүчин төгөлдөр болсноор гэрээний салшгүй нэг хэсэг болно.
- 7.4 Гэрээний хугацаа дууссан тохиолдолд худалдан авагч талын албан ёсны хүсэлтээр гэрээг сунгаж болно.
- 7.5 Энэхүү гэрээнд заагдсан хугацааг хуанлийн хоногоор тоолно.
- 7.6 Энэхүү гэрээтэй холбогдох баримт бичиг, бүх хавсралтууд нь гэрээний салшгүй хэсэг болох ба эдгээр нь адил хүчинтэй хоёр хувь үйлдэгдэж, тал тус бүрт нэг хувь хадгалагдана.

Талуудын албан ёсны хаяг


Худалдагч тал:	Үйлчлүүлэгч тал:
Хаяг: Говьсүмбэр аймаг Сүмбэр сум 3-р баг	Хаяг:
Утас: 88089652,	Утас:
Факс:0	
И-мэйл хаяг:	

Гэрээ байгуулсан:

Нийлүүлэгч талыг төлөөлж:

“Алхана трейд” ХХК –ийн

Салбарын дарга..... /Г.Оюунцэцэг /



Үйлчлүүлэгч байгууллагыг төлөөлж:

нягтлан бодогч..... /Н.Одончимэг /

